

БАТЛАВ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА

Огноо: 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР  
ДУУСVAR БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ  
ХИЙХ АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ САНАЛЫН  
ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

АЛТАЙ ХОТ  
2024 ОН

## БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

- МАЯГТ 1-САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
- МАЯГТ 2-ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
- МАЯГТ 3-ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 4-САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ ХҮСНЭГТ
- МАЯГТ 5-АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- МАЯГТ 6-БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 8-ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 9-ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 11-САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

## САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (СӨХ)

№	Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар. Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 1402 тоот.
2	<p>Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр, тоног төхөөрөмж:</p> <p>Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй аудитын хуулийн этгээд нь Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба тус газрын аудитын багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.</p> <p>Гүйцэтгэгч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.</p> <p>Гүйцэтгэгч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.</p>
3	Гүйцэтгэгчийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай эсэх: “үзүй”
4	<p>Санал хүлээн авах хугацаанаас 1 хоногийн өмнө албан бичгээр ирсэн тодруулгад хариу өгнө.</p> <p>Хаяг: Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар.</p>
5	Саналыг Монгол хэлээр ирүүлнэ.
6	Хураангуй жагсаалтад орсон гүйцэтгэгч, мөн жагсаалтад орсон бусад компанийтай хамтран ажиллаж болно: “үзүй”
7	Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх хугацаа: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглаварт хугацаанд багтаан хийж гүйцэтгэнэ.
8	Гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг: 19,152,000.0 /арван есөн сая нэг зуун тавин хоёр мянга/ төгрөг
9	<p>Гүйцэтгэгчийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод түвшин:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй байх;</li> <li>• Дөрөвөөс доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх;</li> <li>• Хууль эрх зүйн асуудал хариуцсан албан тушаалтантай байх;</li> <li>• Аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч өөр байгууллагад давхар ажил эрхэлдэггүй, бусад аудитын хуулийн этгээдэд гэрээгээр ажилладаггүй байх;</li> </ul>
10	Гүйцэтгэгчийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг Монгол хэлээр бэлтгэнэ.
11	Ажлын даалгаварт заасан бусад нэмэлт шаардлага.

	<i>ГААТАГ2024-01 дугаар ажлын даалгаврыг хавсаргасан.</i>
12	<p>Татвар:</p> <p><i>Гүйцэтгэгч нь хууль, журмын дагуу татвар, төлбөр хураамжийг өөрөө хариуцна.</i></p> <p><i>Гүйцэтгэгч нь гэрээнд заагдсан төлбөрийн хуваарийн дагуу цахим төлбөрийн баримтын системд төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн үед төлбөрийг шилжүүлнэ]</i></p>
13	Санал ирүүлэх тоо: эх хувь 1
14	<p>Санал ирүүлэх хаяг: Цахимаар</p> <p>/Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Сайханжаргалт. saikhanjargalts@audit.gov.mn. Гар утас:88665099./</p>
15	Саналыг 2024 оны 10 дугаар сарын 31-нпа өдрийн 17 цаг 30 минутаас өмнө ирүүлсэн байна.
16	(а) Гүйцэтгэлийн баталгаа шаардахгүй.

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г \_\_\_\_\_ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна. /төсвийн тооцооллыг хавсарган/

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: \_\_\_\_\_

Холбоо барих утас: \_\_\_\_\_

## ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

## 3.1. Ерөнхий танилцуулга

(Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

*Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд нь дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. Нотлох баримтыг хавсарган ирүүлэх шаардлагатай.*

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: \_\_\_\_\_

## САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Мэргэжилтний нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

*Мөн нотлох баримтыг материалд хавсарган ирүүлэх шаардлагатай ]*

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойллыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

МАЯГТ 5

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ<sup>1</sup>

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

МАЯГТ 6

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

МАЯГТ 7

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

Баталгаажуулах

<sup>1</sup> Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.

## I. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### 1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- 1.1 Нэр томъёоны тайлбар
- Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
- (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
  - (б) “Гүйцэтгэгч” гэж захиалагч, шалгагдагч этгээдтэй байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
  - (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
  - (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
  - (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
  - (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
  - (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ.
  - (ё) “Гишүүн” гэж түншлэл/консорциум/холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ. /Хэрэв байгаа бол/
  - (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Гүйцэтгэгчийн аль нэгийг, харин “Талууд” гэж оролцогчдыг нь хэлнэ.
  - (з) “Нөхөн төлөх зардал” гэж Гүйцэтгэгчийн ажлын хөлснөөс бусад үйл ажиллагаатай холбоотой бүх зардуудыг хэлнэ.
  - (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ.
  - (м) “Үйлчилгээ” гэж Ажлын даалгаварт тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
  - (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
  - (ө) “Ажиллах хүчин” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Гүйцэтгэгчийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.
- 1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль
- Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3 Гэрээнд ашиглах хэл
- Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.

1.4	Мэдэгдэл	Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.
1.5	Байршил	Үйлчилгээг ажлын даалгаварт заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харьяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.
1.6	Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ	Гүйцэтгэгч нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбоноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.
1.7	Итгэмжлэгд сэн төлөөлөгч	Гэрээний дагуу захиалагч эсхүл Гүйцэтгэгчийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
1.8	Татвар, хураамж	Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
1.9	Авлигал болон залилан мэхлэх үйлдэл	Захиалагчийг төлөөлөн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй төрийн албан хаагч болон сонгон шалгаруулалтад оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч Гүйцэтгэгч бүр сонгон шалгаруулалтад оролцох, гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.  Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй төрийн албан хаагч болон оролцогч шинжээч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

## 2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

2.1	Гэрээ хүчин төгөлдөр болов	Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.
2.2	Үйлчилгээг эхлэх	Гүйцэтгэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.
2.3	Гэрээний хугацаа дуусгавар болов	ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш талууд гэрээг дүгнэж дуусгавар болгоно.
2.4	Гэрээний өөрчлөлт	Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар

		буюу засвар	хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.
2.5	Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл	2.5.1	Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.
		2.5.2	Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Гүйцэтгэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
2.6	Гэрээ цуцлах		
2.6.1	Захиалагч гэрээг цуцлах	Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй.	
		(а)	Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй:
		(б)	Гүйцэтгэгч (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа:
		(в)	Гүйцэтгэгч нь сонгон шалгаруулалтад оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авлигат, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа:
		(г)	Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Гүйцэтгэгч нь 30-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээг гүйцэтгэх боломжгүй болсон:
		(д)	Захиалагч өөрийн санаачилгаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол:
2.6.2	Шинжээчийн санаачилгаа р гэрээг цуцлах	Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй	
		(а)	Захиалагч нь ГЕН-ийн 8 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг Гүйцэтгэгчийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй:
		(б)	Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Гүйцэтгэгч нь 30-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон:

### 3. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

#### 3.1 Ерөнхий зүйл

3.1.1 Гүйцэтгэлийн чанар	<p>Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстай бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материалын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохицт арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстай.</p> <p>Гүйцэтгэгч нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн Гүйцэтгэгчийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстай.</p> <p>Төрийн аудитын шалгагдагч этгээд байгууллага, түүний ажилтнуудтай харьцах ёс зүйг чанд мөрдөж ажиллах, тэдгээрийн нэр хүндэд халдахгүй байх үүрэгтэй.</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг нь гэрээгээр ажил гүйцэтгэж буй шинжээч аудитын хуулийн этгээд болон түүний ажилтнуудад нэгэн адил үйлчилнэ.</p>
3.2 Ашиг сонирхлын зөрчил	Гүйцэтгэгч нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстай бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхлын зөрчилд орохос зайлсхийх ёстай.
3.3 Нууцлал	Гүйцэтгэгч, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа мэдээллийг аливаа этгээдэд дамжуулах, үйлчилгээний үр дүн, түүнд хамаарах аливаа баримт, тайлан мэдээг нийтэд нээлттэй болгох эрхгүй бөгөөд хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.
3.4 Гүйцэтгэгчийн хариуцах даатгал	Гүйцэтгэгч нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзлын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.
3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа	Гүйцэтгэгч нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстай. Үүнд:
	(а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,
	(б) Гүйцэтгэх ажилд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.
	(в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа
3.6 Тайлagonах хуваарь	Гүйцэтгэгч нь тайлан гаргах хуваарьт заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстай.
3.7 Шинжээчийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь	Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж Гүйцэтгэгчийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид

хүргүүлнэ.

- 3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит Гүйцэтгэгч нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

#### 4. ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖИЛТНУУД

- 4.1 Ажиллах хүчиний тодорхойлолт Гүйцэтгэгчийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарьт тусгана. Захиалагчтай урьдчилан тохиолцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтад багтаана.
- 4.2 Ажилтныг халах буюу солих (a) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчиний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Гүйцэтгэгчийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэнэ.
- (b) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрөхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.
- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсэж болох ямар нэгэн нэмэлт зардлыг гүйцэтгэгч нэхэмжлэх эрхгүй болно.

#### 5. ЗАХИАЛАГЧИЙН БОЛОН ШАЛГАГДАГЧ ЭТГЭЭДИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох Захиалагч нь ГТН-д заасан шинжээчид үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг олгуулахын тулд шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
- 5.2 Гэрээнд хэрэглэх хуульд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуульд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Гүйцэтгэгчийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиолцон гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээт өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.

#### 6. ГҮЙЦЭТГЭГЧИД ТӨЛӨХ ТӨЛБӨР

- 6.1 Нийт төлбөр Гүйцэтгэгчид төлөх нийт төлбөрийн хэмжээ нь ажлын даалгаварт тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчилснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн

	6.2 Гэрээний үнэ	6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно. (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно. (б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр		ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг гаргаж захиалагчаас зөвшөөрөл авна.
6.4 Төлбөр хийх нөхцөл. хуваарь		Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан Гүйцэтгэгчийн дансанд хийнэ. ГТН-д заасан нөхцөл болзлыг хангасны дараа, Гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой.

## 7. ШУДАРГА БАЙДАЛ

7.1 Шударга байдал	Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биений эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгын хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.
--------------------	--

## 8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

8.1 Маргааныг эв зүйтгээр шийдвэрлэх	Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтад ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйтгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
8.2 Маргааныг шийдвэрлэх	Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйтгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

## 9. БУСАД

9.1 Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой талуудын эрх үүрэг	Энэхүү гэрээг захиалагч, гүйцэтгэгч, шалгагдагч этгээд гурван тал баталгаажуулж гарын үсэг зурах бөгөөд талууд холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
---	--

## II. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчилнө.
{1.1(а)}	Гэрээнд хэрэглэх хууль нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж дүрэм, журам болон стандарт.
1.3	Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.
1.4	<u>Захиалагч:</u> Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар. Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 1402 тоот. Төрийн аудитын газрын байр. Харилцах хүн: Аудитын менежер Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 И-мэйл: erdenechimegd@audit.gov.mn
	<u>Гүйцэтгэгч:</u> Харилцах хүн: /нөхөх/ И-мэйл: /нөхөх/
1.8	Гүйцэтгэгч нь хууль журмын дагуу татвар, төлбөр, хураамжийг өөрөө хариуцна.
{2.1}	Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: <i>Гэрээнд оролцогч талууд гарын үсэг зурсан өдрөөс.</i>
2.2	Үйлчилгээ эхлэх хугацаа: <i>Гэрээ байгуулсан өдрөөс гүйцэтгэгч ажлыг эхэлсэнд тооцно.</i>
2.3	Гэрээний дуусгавар болох хугацаа: <i>Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд багтаан хийж гүйцэтгэнэ.</i>
3.4	Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь: Гэрээний туршид Мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байна.
{3.5 (в)}	Бусад үйл ажиллагаа: <i>Гүйцэтгэгч нь ажлын даалгаварт тусгагдсан бүх ажлыг аудитын батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, ажлын баримтуудыг ФАС программд бүрэн оруулж, цахим архив үүсгэж, нотлох баримтуудаа архивлана.</i> <i>Захиалагч гүйцэтгэсэн ажилд чанарын хяналт хэрэгжүүлнэ.</i>
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <i>Нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний үнэ байна. Гэрээний үнэд тохируулга хийж болохгүй.</i>
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхийн байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ.

ЗАХИАЛАГЧ

ШАЛГАГДАГЧ ЭТГЭЭД

ГҮЙЦЭТГЭГЧ

(гарын үсэг)

(гарын үсэг)

(гарын үсэг)

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  
Г.ГҮНЖИДМАА  
(Тамга)

Дарга/ захирал

-ийн

захирал

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар № \_\_\_\_\_

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- Энэхүү гэрээнд оролцогч талууд болох Захиалагч **Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын** (цаашид “захиалагч” гэх), шалгагдагч ..... (цаашид “шалгагдагч этгээд” гэх), гүйцэтгэгч ..... (цаашид “гүйцэтгэгч” гэх) нь дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) 202... оны ... дугаар сарын ...-ны өдөр байгуулав.
- Гүйцэтгэгч нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
- Захиалагч нь Санхүүгийн тайллангийн аудитын ажил гүйцэтгэх ..... дугаартай “Шалгагдагч этгээдийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх” гэрээт ажлыг (цаашид “ажил” гэх) санал болгосон үнэ буюу ..... (.....) төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлснийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - Гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл;
  - Гэрээний ерөнхий нөхцөл;
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Ажлын даалгавар;
  - Тайлан гаргах хуваарь;
  - Ажиллах хүчин-туслан гүйцэтгэгч, Ажлын хөтөлбөр хуваарь, болон аргачлал.
- Гэрээ /ГЕН, ГТН/ нь энд дурдсан ажил гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.
- Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Хоёр. Үүрэг хариуцлага

- Төрийн аудитын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн үүрэг нь гэрээгээр ажил гүйцэтгэж буй аудитын хуулийн этгээд болон түүний ажилтнуудад нэгэн адил үйлчилнэ.

- 2.2. Захиалагч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийх аудитын ажил болон зөрчил, дутагдлыг арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.
- 2.3. Шалгагдагч этгээд нь аудитын үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Гүйцэтгэгчид гарган өгч болно.
- 2.4. Шалгагдагч этгээд нь гүйцэтгэгчийн шаардсан аудиттай холбоотой, тайлан, тооцоо, санхүүгийн баримт, мэдээлэл, судалгаа, тайлбар, тодруулга тодорхойлолт, холбогдох бусад бүх баримт материалыг саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.
- 2.5. Шалгагдагч этгээд нь гүйцэтгэгчийг шалгагдагч этгээдийн байранд ажиллах нөхцөл бололцоогоор хангах үүрэг хүлээнэ.
- 2.6. Шалгагдагч этгээд аудит хийхэд шаардагдах мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцна.
- 2.7. Шалгагдагч этгээд нь аудитын төлбөрийг цахим нэхэмжлэлийг үндэслэн 100.0 хувь Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь 100900024401 тоот дансанд гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор байршуулна.
- 2.8. Шалгагдагч этгээд нь аудитыг гүйцэтгэж буй аудитын хуулийн этгээдийн үйл ажиллагаанд саад учруулсан, аливаа дарамт, шахалт, хууль бус нөлөө үзүүлсэн тохиолдолд нөлөөллийн мэдүүлэг хөтөлж, Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ.
- 2.9. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан аудитын ажлыг гүйцэтгэж, зөрчил, дутагдлыг арилгах, зөвлөн туслах үүрэг хариуцлагыг хүлээж, хараат бусаар ажиллана.
- 2.10. Гүйцэтгэгч нь төрийн аудитын болон үйлчлүүлэгч байгууллага түүний ажилтнуудтай харьцах ёс зүйг чанд мөрдөж, тэдгээрийн нэр хүндэд халдахгүй байх үүрэгтэй.
- 2.11. Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс аудитын үйл ажиллагаанд оролцож буй аудитын хуулийн этгээд нь аудит гүйцэтгэхдээ Төрийн аудитын тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, гэрээгээр аудит хийх журам, холбогдох бусад дүрэм, журмыг баримтлан хараат бус, авилгаас ангид ажиллана.
- 2.12. Гүйцэтгэгч нь аудитаар илэрсэн асуудлыг захиалагч талд танилцуулсны дараа шалгагдагч этгээдэд хүргүүлэх бөгөөд зарчмын зөрүүтэй асуудлаар 3 талын уулзалт зохион байгуулж, шийдвэрлэнэ.
- 2.13. Талууд бүрэн эцэслээгүй тайлан, дүгнэлтийг бусдад танилцуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.
- 2.14. Талууд нууц мэдээллийг зохих зөвшөөрөлгүй задруулсан буюу ашигласан бол хуулийн хариуцлага хүлээлгэнэ.
- 2.15. Аудитыг Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд гүйцэтгэж дуусгаагүй, хугацаа хоцроосон, аудитын үе шатны ажилбаруудыг чанаргүй гүйцэтгэсэн, ёс зүйн алдаа гаргасан, шалгагдагч этгээдээс гаргасан гомдол нотлогдсон тохиолдол, үр дагавраас хамаарч үнэлгээг бууруулах эсвэл тэрээг цуцлах үндэслэл болно.

### **Гурав. Төлбөр**

- 3.1 Төлбөрийг дараах хуваарийн дагуу Татварын цахим төлбөрийн баримтын системээр баталгаажсан баримтыг үндэслэн төлнө.

- 3.1.1 Гэрээний үнийн дүнгийн 60.0 хувьтай тэнцэх дүнг аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсны дараа, цахим нэхэмжлэлийг үндэслэн ажлын 5 хоногийн дотор төлнө.
- 3.1.2 Гэрээний үнийн дүнгийн 30.0 хувьтай тэнцэх дүнг захиалагч аудитын гэрчилгээ, тайланг хүлээн авч баталсны дараа, цахим нэхэмжлэлийг үндэслэн ажлын 3 хоногийн дотор төлнө.
- 3.1.3 Гэрээний үнийн дүнгийн 10.0 хувьтай тэнцэх дүнг УИХ-ын чуулганы хуралдаанаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын Нэгдсэн Төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын ажлын талаар эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд аудитын тайлагналын дараах үе шатны ажлын гүйцэтгэл, цахим нэхэмжлэлийг үндэслэн ажлын 10 хоногийн дотор төлнө.
- 3.1.4 Холбогдох журам, чанарын үнэлгээгээр 85.0 буюу түүнээс доош оноотой үнэлэгдсэн, эрсдэлтэй асуудал үүссэн тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 10.0 хувьтай тэнцэх санхүүжилтийг олгох эсэх асуудлыг үүссэн нөхцөл байдлын үр дагавраас хамаарч аудитын багийн саналыг үндэслэн дарга, тэргүүлэх аудиторт танилцуулж шийдвэрлэнэ.

#### **Дөрөв. Бусад зүйл**

- 4.1. Гэрээнд холбогдох асуудлаар талууд зөвхөн албан бичгээр харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер .....  
.....

**ШАЛГАГДАГЧ ЭТГЭЭДИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

Д.Эрдэнэчимэг

Хаяг: /.....

Утас:/...../

Утас: /...../

Шалгагдагч этгээдийн банкны дансны  
дугаар: Төрийн сан  
.....

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

..... Захирал

..... / .....

Хаяг: .....

Гүйцэтгэгч байгууллагын харилцагч  
банкны дансны дугаар: .....  
банк .....

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙХ АУДИТЫН  
АЖЛЫН ДААЛГАВАР

2024.10.23

Дугаар: ГААТАГ 2024-01

Алтай хот

Ажлын зорилго: Төсвийн шууд захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайландаа аудит хийх

Ажил гүйцэтгэх хугацаа: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд багтаан хийж гүйцэтгэнэ.

**НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Төрийн аудитын байгууллага энэ хуульд заасан санхүүгийн тайландаа аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно” гэж заасны дагуу Төрийн аудитын байгууллага (цаашид “Захиалагч” гэх) төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх аудитын хуулийн этгээд (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу сонгон шалгаруулах шаардлагатай болсон.

**ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ**

Гүйцэтгэгч нь Төсвийн шууд захирагчийн бэлтгэсэн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС, эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэл, тайллагналын холбогдох заавар, журамд нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн холбогдох шаардлагын дагуу бэлтгэсэн болон ажил гүйлгээгээр гарсан харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, стандартын дагуу бэлтгэсэн эсэхийг үндэслэлтэй баталгаагаар нотлох;
- Төсвийн шууд захирагч нь төсвийг тооцоо судалгаанд үндэслэн төсвийн оновчтой бодлого, чиглэл баримталж төлөвлөж, зарцуулсан эсэхийг хянаж нягтлах.

Гүйцэтгэгч нь Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд анхаарах асуудал, баримтлах нэгдсэн бодлого, зааврыг аудитын явцад мөрдөж эрсдэлтэй асуудалд аудитор, шинжээчийн нөөцийг төвлөрүүлэх замаар аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллана. Мөн нийцлийн аудитыг хослуулан гүйцэтгэж, Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг аудитад иж бүрэн хамруулна.

Гүйцэтгэгч аудитын үе шатны ажлыг АДБОУС, Төрийн аудитын стандарт MNS 6817 2020, АУОС-д нийцүүлэн гүйцэтгэнэ. Үүнд:

- Аудитын урьдчилсан үйл ажиллагааны үе шат;
- Аудитыг төлөвлөх үе шат;

- III. Аудитыг гүйцэтгэх үе шат;
- IV. Аудитыг тайлагнах үе шат;
- V. Аудитын дараах үйл ажиллагааны үе шат

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитын үе шатны ажлуудыг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал" болон бусад дүрэм, журмын дагуу гүйцэтгэж, баримтжуулан баталгаажуулна.

Аудитын үе шатны ажлын гүйцэтгэл, үр дүн, холбогдох нотлох баримтуудыг Санхүүгийн тайлангийн аудитын цахим (FAS) системд тухай бүрд оруулан чанарын хяналт хийлгэнэ.

## 1. АУДИТЫН УРЬДЧИЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТ

**Зорилго:** Аудитын урьдчилсан үйл ажиллагааны үе шатанд аудитын урьдчилсан нөхцөлүүд бүрдсэн эсэхийг тодорхойлно.

**Аудитын урьдчилсан үйл ажиллагааны үе шатанд дараах ажлыг гүйцэтгэж, баримтжуулна. Үүнд:**

- Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг үнэлэх;
- Удирдлагын хүлээх үүрэг хариуцлагын тухай ойлголтыг бүрдүүлэх;
- Багийн гишүүдийн ёс зүйн шаардлагыг үнэлэх, ашиг сонирхлын зөрчилгүй тухай болон зөрчил үүссэн тухай мэдэгдэл гаргах;
- Нөлөөллийн мэдүүлгийн талаар танилцуулах;
- Аудитын ажлын захидал бэлтгэж шалгагдагч этгээдэд хүргүүлэх, аудитын нээлтийн уулзалт хийх;

## 2. АУДИТЫГ ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

**Зорилго:** Аудитын төлөвлөлтийн үе шатанд Санхүүгийн тайлагналын материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, аудитын төлөвлөлтийн ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг тодорхойлох, үнэлсэн эрсдэлд өгөх хариуг зохиомжлох ба цаашдын аудитын горимуудын шинж чанар, хугацаа болон хамрах хүрээг тодорхойлно.

Аудитыг төлөвлөж, гүйцэтгэхдээ шалгагдагч этгээдийн санхүүгийн тайланг материаллаг хэмжээгээр буруу илэрхийлэхэд хүргэсэн нөхцөл байдал байж болзошгүй гэсэн мэргэжлийн үл итгэх байр сууринеас хандана.

**Аудитыг төлөвлөх үе шатанд дараах ажлыг гүйцэтгэж, баримтжуулна. Үүнд :**

- Шалгагдагч байгууллага, түүний орчныг ойлгох;
- Санхүүгийн тайлан болон батламж мэдэгдлийн түвшинд материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлох;
- Санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан эрсдэлтэй асуудал шалгагдагч байгууллага байгаа эсэхийг тодорхойлох;
- Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлээс сэргийлэх ба илрүүлэх дотоод хяналтыг тодорхойлох;
- Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг тодорхойлох ;
- Эрсдэлийг үнэлэх;
- Үнэлсэн эрсдэлд өгөх хариуг зохиомжлох;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийх горим сорилыг тодорхойлох;
- Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж батлуулах;
- Аудитын үр өгөөжийг урьдчилан төлөвлөх;

### **3. АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ҮЕ ШАТ**

Зорилго: Аудитыг гүйцэтгэх үе шат нь аудитор төлөвлөлтийн үе шатанд тодорхойлж аудитын нарийвчилсан төлөвлөгөөнд тусгасан аудитын горим, сорилыг гүйцэтгэх, гүйцэтгэсэн горим, сорилд үндэслэн гаргасан дүгнэлтээ баримтжуулах, аудитын нотолгоог бүрдүүлнэ.

Аудитыг гүйцэтгэх үе шатанд дараах ажлыг гүйцэтгэж, баримтжуулна. Үүнд :

- Шалгах зүйлсийг сонгох;
- Аудитын төлөвлөгөөнд тусгасан горимуудыг гүйцэтгэх;
- Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмжийн дагуу төсвийн гүйцэтгэлд горим гүйцэтгэх;
- Өмнөх оны аудитаар өгсөн төлбөрийн акт , албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх;
- Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг шалгах ;
- Ерөнхий чиглэлд тусгагдсан эрсдэлтэй асуудалд горим, сорил гүйцэтгэх ;
- Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл болон Төрийн аудитын байгууллагаас боловсруулсан маягтын дагуу судалгаа гаргах;
- Аудитыг гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолох;
- Гүйцэтгэсэн ажлын үр дүнг баримтжуулах, нотлох баримтыг цуглуулах, аудитын нотолгоог үнэлэх;
- Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэлийг хөтлөх;
- Буруу илэрхийллийг мэдээлэх ба запруулах;
- Аудитын хаалтын уулзалт зохион байгуулж, аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл, төлбөрийн акт, албан шаардлагыг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, хариу тайлбарыг авч эцсийг шийдлийг гаргах;

### **4. АУДИТЫГ ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТ**

Зорилго: Аудитор аудитын нотолгоонд үндэслэн хийсэн дүгнэлтийн үр нөлөөг үнэлсний үндсэн дээр аудитын тайланг бэлтгэнэ. Аудиторын зорилго нь олж авсан аудитын нотолгоонд үндэслэн санхүүгийн тайлангийн тухай дүгнэлт гаргах болон уг дүгнэлтийн үндэслэлийг тайлбарласан ойлгомжтой тайлан бичих юм.

Аудитыг тайлагнах үе шатанд дараах ажлыг гүйцэтгэж баримтжуулна.

- Аудитын тайланд асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсгийг тодорхойлж тусгах;
- Аудитын гол асуудлыг тодорхойлж тусгах;
- Илрүүлсэн эсвэл сэжигтэй зөрчлийг тайлагнах;
- Эрсдэл бүхий асуудалд чиглэсэн аудит хийх шаардлагатай эсэх;
- Аудиторын тайлан дахь дүгнэлтийг боловсруулах;
- Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн эцэслэн баталгаажуулах;
- Аудитын тайланг батлагдсан загварын дагуу боловсруулах;
- Аудитын хураангуй тайлан, зөрчлийн нэгтгэл, төрийн аудитын байгууллагаас тухайн жилд баримтлах бодлого, чиглэлийн дагуу боловсруулсан судалгааг үнэн зөв, иж бүрэн гаргуулан авч, хянасан байх;
- Аудитын тайланг хэвлэлтэд бэлтгэж, цахимаар хүлээлгэж өгөх;

## **5. АУДИТЫН ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТ**

Аудитын тайлагналын дараах үе шатанд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Статистик мэдээг батлагдсан маягтаар иж бүрэн гаргаж нэгтгүүлэх;
- Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, нотлох баримтын хамт ирүүлэх;
- Гүйцэтгэгч нь аудитын ажлын баримт, нотлох зүйлсийн архивын нэгжийг цахим хэлбэрээр ирүүлэх.

## **ГУРАВ. АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮРЭГ , ХАРИУЦЛАГА**

Гүйцэтгэгч дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Аудитыг тасралтгүй хэрэгжүүлэх ба аудитаар хийх үе шатны ажилбар бүрийг бүрэн хэрэгжүүлэх мэдлэг, туршлагатай аудиторуудыг багтаасан аудитын багийг томилсон байх ;
- Аудитыг гүйцэтгэгч болон түүний томилсон баг аудитын бүх үе шатны ажлуудыг хуулийн хугацаанд бүрэн чанартай хэрэгжүүлэх;
- Гүйцэтгэгчийн удирдах ажилтнууд аудитыг үр дүнтэй хийхэд анхаарч, аудитын үе шат бүрд чанарын хяналтыг хэрэгжүүлж баримтуулах;
- Аудитын явцад олж авсан мэдээллийг төрийн аудитын үйл ажиллагаанд ашиглахаас өөр зорилгоор хөндлөнгийн этгээдэд дамжуулах, хувийн буюу бусдын ашиг сонирхлын төлөө ашиглуулахгүй бөгөөд мэдээллийн нууцыг чанд хадгалах.

Гүйцэтгэгч гэрээгээр аудит хийхдээ Төрийн аудитын стандартад заасан хараат бус байх, нууцыг хадгалах, ёс зүйг мөрдөх зарчмуудыг баримтална.

## **ДӨРӨВ. АЖЛЫН ХАМРАХ ҮҮРЭЭ**

Шалгагдагч этгээдийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгууд, ерөнхий дэвтэр, журнал, анхан шатны баримт, төсвийн гүйцэтгэлийн тайлан, шаардлагатай бусад баримтуудыг хамарна.

Гүйцэтгэгч санхүүгийн тайлангийн аудитын зорилтыг хангах үүднээс шаардлагатай гэж үзсэн аудитын горимуудыг хэрэгжүүлнэ.

Аудитыг АДБОУС-ын дагуу гүйцэтгэхэд шаардагдах горимуудыг гүйцэтгэгч тодорхойлох бөгөөд ингэхдээ АДБОУС, хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлагууд, мөн тохиромжтой бол аудитын ажлын нөхцөл, тайлагнах шаардлагуудыг харгалзана.

Аудитын үндэслэлтэй баталгаа: Санхүүгийн тайлан бүхэлдээ материаллаг буруу илэрхийллээс ангид гэсэн үндэслэлтэй баталгаа гаргахад чиглэнэ. Үндэслэлтэй баталгаанд санхүүгийн тайлан бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэл агуулаагүй гэж дүгнэхэд аудиторт шаардагдах аудитын нотлох зүйл цуглуулахтай холбоотой ойлголт хамаарна.

## **ТАВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН**

Шалгагдагч этгээдийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын баталсан нягтлан бodoх бүртгэл, тайлагналын холбогдох заавар, журамд нийцүүлэн үнэн зөв гарсан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулна.

Аудитын ажлын гүйцэтгэлээр шалгагдагч этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналт, тайлагналыг сайжруулах зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд төлбөрийн акт тогтоох, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгнө.

## **ЗУРГАА. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Гүйцэтгэгч нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хун, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Төрийн аудитын байгууллагын санхүү, нийцлийн аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Тус ажлыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэхээр шалгарсан аудитын хуулийн этгээд нь захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, аудитын багтай уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Үе шатны ажлын явцад бий болсон шийдвэрлэх боломжгүй асуудлыг тухай бур захиалагч талын холбогдох албан тушаалтанд мэдэгднэ.

Аудитын явцад тавих чанарын хяналтыг аудитын хуулийн этгээд өөрийн хүрээнд иж бүрэн гүйцэтгэхээс гадна аудитын явц, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Үндэсний аудитын газарт хүргүүлж, аудитыг нэгтгэж удирдах боломжоор хангана.

Захиалагч Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А /81 тушаалаар баталсан "Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам"-ын дагуу тухайн аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн аудитын ажилд үнэлгээ өгч, холбогдох арга хэмжээ авч ажиллана.

## **ДОЛОО. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА**

Аудитыг гүйцэтгэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Гүйцэтгэгч нь аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх;
- Аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй байх;
- Үйл ажиллагаа явуулах боломжтой ажлын байр, техник хэрэгсэлтэй байх;
- Аудитын багийн гишүүд нь шалгагдагч этгээдийн аль нэг албан тушаалтантай садан төрөл, бусад байдлаар хамааралгүй байх ;

Ажиллах хүчиний шаардлага:

- Дөрвөөс доошгүй үндсэн орон тооны, хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчтой байх;
- Хууль эрх зүйн асуудал хариуцсан албан тушаалтантай байх ;
- Аудитын байгууллагад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогч өөр байгууллагад давхар ажил эрхэлдэггүй, бусад аудитын хуулийн этгээдэд гэрээгээр ажилладаггүй байх;

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв, чанартай хэрэгжүүлэх.

## **НАЙМ.ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Төсвийн шууд захирагчийн шилжүүлсэн аудитын төлбөрийг Захиалагч гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу гүйцэтгэгчид олгоно.

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**